<li>Суурин компьютерийн системийн гэмтэлийн засвар 85, принтер засвар 30, бар код програм хангамж 19, пос принтерийн програм хангамж 20, цахим эрүүл мэнд төслийн 2 процессорын их хавтан шатсан тул IT zone засварт өгч засуулсан, серверийн айр кондейшний хөргөгч шингэн алдагдан хөргөх нөхцөл 29 градусаас доош буухгүй байсан тул Метронетворк ХХК засварын багийг дуудан засуулсан, хяналтын камер аналоги камер төв салбарт 12, яармаг салбарт 6 ширхэгийг засварлан байршил, харалтын өнцөг өөрчлөн суурьлуулсан. DVR 16 сувгийн 21 хоногийн хугацаатай бичлэг хадгалах боломжтой 2 ширхэг байршуулав. Төхөөрөмжүүдийг дотоод сүлжээгээр дамжуулан хяналтын дэлгэцийг эмнэлгийн хамгаалтын ажилтан болон ЭЭО даргын өрөөнд LCD 42 инч дэлгэц суурьлуулан байнгын ажиллагаатай болгов. Байгууллагын дотоод өнгө үзэмж, цахилгааны аюулгүй байдалд нөлөөлөх 5 ширхэг камерын тэжээлийн утасны холболтыг цэгцлэн, тасралтгүй эх үүсгэвэрт холболт хийлгэсэн.</li>
</ol>
✓ Төв салбар: Давхар бүрт 2, гадна 2 камер, яаралтай хүлээн авах хэсэгт 2 аналоги камер байршуулан ажиллаж байна.
✓ Яармаг салбарт: Давхар бүрт 2, гадна 2 аналоги камер ажиллаж байна.
Зорилт 5. Нийт сумдыг (ӨЭМТ) хамарсан алсын зайн үндэсний сүлжээ бий болгох
</td></tr>
</table>

<table>
<tr>
<td></td>
<td></td>
<td>2018 онд 16 өрхийн эрүүл мэндийн төвүүдийг шилэн кабелийн оптик холболт үүсгэн дотоод сүлжээний нэгдсэн удирдлагаар хангагдсан. Төв салбарт сүлжээний тойм зураг гарган босоо 2, хөндлөн 4 сувагчлалаар, яармаг салбар босоо 1, хөндлөн 2 сувагчлалаар дамжуулах холболтын ажил хийгдсэн бөгөөд дотоод сүлжээг дахин зохион байгуулах ажлыг 2018 оны 5 сараас үр дүнгийн гэрээнд тусгагдсаны дагуу шинэчилж зохион байгуулж байна. Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн дотоод сүлжээг нийслэлийн мэдээлэл технологийн газрын инженерүүдтэй хамтран зохион байгуулж өрх бүрт 1 ширхэг 16 port switch ethernet 10/100 холболтоор холбон дотоод сүлжээний хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн.<br><br>Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын 2018 оны 04 сарын 18 өдрийн 1/382 тоот тушаалын хэрэгжилтийн хүрээнд eHealth програм хангамжийн сургагч багш бэлтгэх сургалтанд дүүргийн 16-н өрхийн эрүүл мэндийн төв тус бүрээс нэг эмчийг сургалтанд хамруулав. 16-н өрхийн эрүүл мэндийн төвүүдийг нийслэлийн нэгдсэн сүлжээнд холбож цахим мэдээллээ тасралтгүй солилцох нөхцөлийг бүрдүүлж улирал тутамд өрхийн эрүүл мэндийн төвүүдээр мэдээлэл технологийн ажилтан тойрч мэргэжил арга зүйгээр хангах ажиллаж байна</td>
</tr>
<tr>
<td>4</td>
<td>Улсын болон нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл</td>
<td>
<table>
<tr><td>1.</td><td>Төслийн нэр:</td><td>Ахмадаа дээдэлье</td></tr>
<tr><td>2</td><td>Хандивлагч байгууллага<br><br>-Дотоодын<br><br>-Гадаадын</td><td>Хан-Уул Дүүргийн Засаг Даргын тамгын газрын иргэдийн төлөөлөгчдийн хурал</td></tr>
<tr><td>3</td><td>Төсөл хэрэгжсэн байгууллага, салбар амбулатори, тасаг нэгж, кабинетийн нэр</td><td>Хан-Уул Эрүүл Мэдийн Төв, Ахмадын кабинет</td></tr>
<tr><td>4</td><td>Төслийг хариуцан хэрэгжүүлсэн, буюу зохицуулагч яам агентлаг байгууллага</td><td>Хан-Уул Дүүргийн Засаг Даргын Тамгын Газар</td></tr>
<tr><td>5</td><td>Төслийн хамарсан хүрээ (төсөлд хамрагдах, амбулатори, тасаг нэгж, кабинет)</td><td>Хан-Уул Эрүүл Мэдийн Төв, Ахмадын кабинет</td></tr>
<tr><td>6</td><td>Төслийн зорилго</td><td>Ахмады үйлчилгээний чанарыг дээшлүүлэх</td></tr>
<tr><td>7</td><td>Төслийн хүрээнд хийгдсэн гол ажлууд, хүрсэн үр дүн</td><td>Кабинет тохижуулсан</td></tr>
</table>
</td>
</tr>
</table>

| | | |
|---|---|---|
| | | Тоног төхөөрөмжөөр хангасан<br><br>Үзлэг оношилгоонд хамрагдана |
| 8 | Төслийн нийт төсөв (мян.ам.доллар, эсвэл монгол мөнгөөр) | 9,992,000 төгрөг |
| 9 | Төслийн санхүүжилтын хэлбэр (Буцалтгүй тусламж, зээл) | Буцалтгүй тусламж |
| 10 | Дотоод эх үүсвэрийн санхүүжилт | - |
| 11 | Төслийн хэрэгжилтийн хувь | 100% |
| 12 | Төслийг хэрэгжүүлэхэд тулгарсан гол бэрхшээл, цаашид авах арга хэмжээ | Байхгүй |

2017 онд ахмадын кабинетыг байгуулсан ба ахмадын кабинет нь  дараах үйл ажиллагааг явуулж байна.

1. ХУД-ийн 4,5,6,7,9,10,14,15, –р хороодын ахмад настнуудад халдварт болон халдварын бус өвчний эрт илрүүлэг хийх урьдчилан сэргийлэх үзлэгийг дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хавдар, нүд лор, сүрьеэ төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг нийт 5243 ахмадуудад хийсэн.
2. Ахмад настны дунд эрүүл аж төрөх зан үйлийг дэмжих сургалт сурталчилгааг дараах сэдвүүдээр явуулж ирлээ. Үүнд: Осол гэмтлээс сэргийлэх, Эрүүл зөв хооллолт, Дасгал хөдөлгөөний ач холбогдол, Архи тамхины хор уршиг, эмийн зохистой , Хорт хавдараас сэргийлье, АД ихсэх өвчнөөс сэргийлье, Чихрийн шижин чимээгүй тахал сэдэвт сургалтанд 1523 ахмад хамрагдсан.
3. Мөн эдгээр сэдвүүдээр гарын авлага, брошур хийж 1678 ахмадуудад тараасан ба ганцаарчилсан зөвлөгөө зөвлөмжийг 1218 ахмадуудад өгсөн.
4. Эрүүл мэндийн 4 ба 5-р бүлэгт хамрагддаг ахмад настанг гэрийн эргэлт тогтмол графикийн дагуу хийж шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нарт  дуудлагаар үзүүлж байна.
5. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2807 ахмадуудадэлэгний В,С вирус илрүүлэх эрт илрүүлгийн шинжилгээнд хамруулсан.

6.Умайн хүзүүний хавдарыг эрт илрүүлэх умайн хүзүүний эсийн  шинжилгээнд 856 ахмадуудыг хамруулсан байна.

<table>
<tr><td rowspan="14">6,7</td><td rowspan="14">Үндэсний хөтөлбөр болон дэд хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл</td><th>№</th><th>Хөтөлбөрийн нэр</th><th>Хэрэгжих хугацаа</th><th>Хэрэгжилтийн хувь</th></tr>
<tr><td>1</td><td>Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр</td><td>I үе шат 2017 - 2019 он II үе шат 2019 - 2025 он</td><td>93,7%</td></tr>
<tr><td>2</td><td>Халдварт бус өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөр</td><td>I үе шат: 2017-2019 он;<br><br>II үе шат: 2020-2021 он</td><td>90,7%</td></tr>
<tr><td>3</td><td>Биеийн тамир спортыг хөгжүүлэх цогц хөтөлбөр</td><td>I үе шат 2011 - 2013 он II үе шат 2013 - 2020 он</td><td>63%</td></tr>
<tr><td>4</td><td>Мансууруулах эм. Сэтгээцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр</td><td>I үе шат 2017 - 2019 он II үе шат 2019 - 2021 он</td><td>80%</td></tr>
<tr><td>5</td><td>Нийслэлийн эрүүл мэнд дэд хөтөлбөр</td><td>I үе шат - бэлтгэл үе шат 2017 он II үе шат – хэрэгжүүлэх үе шат 2018 - 2020 он</td><td>43%</td></tr>
<tr><td>6</td><td>Орчны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр</td><td>201 - 2020 он</td><td>48,7%</td></tr>
<tr><td>7</td><td>Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээни й шинэчлэлийн стратеги</td><td>2013 - 2018 он</td><td>50%</td></tr>
<tr><td>8</td><td>Сэтгэцийн эрүүл мэнд үндэсний 2 дахь хөтөлбөр</td><td>2010 - 2019 он</td><td>90%</td></tr>
<tr><td>9</td><td>Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөр</td><td>2017 - 2021 он</td><td>87,95%</td></tr>
<tr><td>10</td><td>Хотжилт ба эрүүл мэнд хөтөлбөр</td><td>2016 - 2020 он</td><td>49,6%</td></tr>
<tr><td>11</td><td>Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг нийгэм хамт олонд түшиглэн сэргээн засах “Тэгш дүүрэн” хөтөлбөр</td><td>2011 - 2017 он</td><td>50%</td></tr>
<tr><td>12</td><td>Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн орчныг сайжруулах тав дахь хөтөлбөр</td><td>2017 - 2020 он</td><td>90%</td></tr>
<tr><td>13</td><td>Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр</td><td>2016 - 2025 он</td><td>90,6</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| 14 | Хүүхдийн насны онцлогт тохирсон хөгжлийг дэмжих дэд хөтөлбөр | 2017 - 2020 он | 45% |
| 15 | Элэг бүтэн монгол үндэсний хөтөлбөр | 2017 - 2020 он | 83,3 |
| 16 | Эрүүл зан үйл төлөвшүүлэх мэдээлэл сургалт сурталчилгааны үндэсний хөтөлбөр | 2010 - 2016 он | 60% |
| 17 | Эрүүл насжилт, настны эрүүл мэнд үндэсний хөтөлбөр | 2009 – 2030 он | 50% |
| 18 | Эх хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд үндэсний хөтөлбөр | 2017 - 2021 он | 49% |
| 19 | Эрүүл ажлын байр | 2017 - 2020 он | 45% |
| 20 | Эрүүл залуус аян | 2017 - 2020 он | 45% |
| 21 | Сүрьеэгүй Хан - Уул | 2017 - 2020 он | 50% |
| 22 | Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги | 2015 – 2020 он | 90% |
| 23 | Гэртээ харих зам | 2015 – 2020 он | 43% |
| 24 | Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр | 2016 – 2020 он | 30% |

| | | |
|---|---|---|
| 8 | Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлт тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл | **Зорилт 1. Сүрьеэгүй Улаанбаатар хөтөлбөрийн хүрээнд сүрьеэгийн өвчлөлийг бууруулах ажлыг дүүргүүдэд үе шаттайгаар хэрэгжүүлнэ**<br><br>**Зорилт 1.1 "Сүрьеэгүй ХАН УУЛ " өдөрлөг зохион байгуулна**<br><br>2018 оны "Сүрьеэ өвчинтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг дэлхий нийтээрээ "Манлайлагчдыг хайж байна", "Сүрьеэг устгая", "Та ч байж болно", "Түүхийг бүтээ" уриан дор тэмдэглэн өнгөрүүлсэн билээ. Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдрийн арга хэмжээг НЭМГ-ын даргын А/34 дүгээр тушаал, ЭМТ-ийн даргын А/28 тушаалын дагуу удирдамж төлөвлөгөө гарган 3-р сарын 14-өөс 4-р сарын 07-ны хооронд "Сүрьеэг устгая" уриан дор олон нийтэд чиглэсэн томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулж байгаагийн нэг нь "Сүрьеэгүй Хан-уул" өдөрлөг юм. |

Бүх хэлбэрийн сүрьеэгийн илрүүлэлтийн хувийг улсын хэмжээнд 2020 онд 45%-д хүргэхээр зорьж байна. Манай дүүргийн хэмжээнд 2017 оны байдлаар 37,8% байсан ба 2018 оны эхний 5 сарын байдлаар 41%-д хүргэн






ажиллалаа.

Уг өдөрлөгийн хүрээнд сүрьеэ өвчинтэй тэмцэх үйл хэрэгт олон нийтийн анхаарлыг хандуулах, хүн бүрийн хүчин чармайлт чухал гэдгийг сурталчлан таниулах зорилгоор халдварын тархалт, халдвараас сэргийлэх талаарх мэдээллийг хийж, иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Өдөрлөгийн хүрээнд 300 гаруй иргэнд 5 төрлийн 1000 гарын авлага, 300 амны хаалт тарааж, сургалт сурталчилгааг хийлээ. Нийт 171000 төгрөг байгууллагын төсвөөс гаргасан.
- Гарын ариун цэврийг сахих, гар халдваргүйтгэх дарааллыг зааж сургах
- Сүрьеэгийн халдвараас сэргийлэх, ханиаж найтаах соёл, гар угаах дараалал, маскны зөв хэрэглээ зэрэг 5 төрлийн гарын авлага бэлтгэн тараах
- Ханиалгасан, амьсгалын замын өвчтэй иргэдэд амны хаалт тараах
- ЭМТ-өөр үйлчлүүлж буй иргэдэд халуун чацаргана, жүүсээр үйлчлэх
- Дүүргийн сүрьеэ диспансерийн үйл ажиллагааг сурталчлан иргэдэд шуурхай үйлчлэх
- Тэмдэглэлт өдрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор UBS телевизэд ярилцлага өгөх
- Эмнэлгээр үйлчлүүлж буй 120 иргэнд "Сүрьеэгийн халдвар" сэдэвт сургалт хийх зэрэг үйл ажиллагааг явууллаа.

**Зорилт 1.2 ЕБС-н ахлах ангийн сурагчдад буюу оюутан сурагчдад сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулна**

| | | |
|---|---|---|
| | | Харьяа хүүхдийн байгууллагад сүрьеэгээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл, сургалтыг 29, 41, 49, 230, 209, 219, 63, 67, 71, 72-р цэцэрлэг, 7, 10, 15, 18, 34, 41, 47, 59, 52, 60, 114, -р сургуулийн 1975 багш, сурагчдад хийж, гарын авлага, сурталчилгааны материалаар хангаж ажилласан байна.<br><br>5-р сарын 28,29,30-нд дүүргийн 7,41,34,32,10,75-р сургуулийн тус бүр 200 хүүхэд нийт 1200 сурагчдад “Сүрьеэгийн өртөөчилсөн “сургалтыг Сүрьеэ диспансер, МӨАУМХ ,ХУДӨС зөвлөлтэй хамтран зохион явуулж нийт 8 өртөөгөөр аялуулан сурагчдад сүрьеэ өвчний тухай хэрхэн урьдчилан сэргийлэх, эмчилгээ оношлогоог эрт хийлгэхийн ач холбогдол зэрэг сэдвээр насанд нь тохирсон мэдлэг мэдээлийг олгож сургууль бүрд 5 идэвхтэй оролцсон сурагчдыг шагнаж урамшууллаа.<br><br>**Зорилт 2. Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүлжүүлэх арга хэмжээг үе шаттай зохион байгуулна**<br><br>Сургуулийн болон сургуулийн өмнөх насныхны дунд зонхилон тохиолдох шүд цоорох өвчлөлийг эрт илрүүлж, цаашдын хүндрэл үүсэхээс урьдчилан сэргийлэх, өвчтэй илэрсэн хүүхдүүдийг эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авах, хүүхэд, багш,эцэг эхчүүдэд сургалт явуулж, амны хөндийн эрүүл мэндийн тухай мэдлэг, амны хөндийг зөв арчлах дадлага олгох замаар шүд цоорох өвчний тархалт, эрчмийг бууруулах.Үүний дагуу дараахь зорилтуудыг тавин ажиллаа. |

<u>Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үзлэг</u>   Ногоон- *2017 он*   Цагаан- *2018 он*

| Хийгдсэн газар | | Хамрагдсан хүний тоо | | Өвчтэй илэрсэн | | Тархалт | | Эрчим | | Үзлэгээс эрүүлжсэн | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 41,53,28,46,134,49 цэцэрлэг 75, 60,118-р сургууль | 29,46,71,73,230 35,218 цэцэрлэг 7,52,15,75,32, 130,118,34,4160 сургууль | 1778 | 4311 | 1104 | 3373 | 62,5 % | **78,2 %** | 4,4 | **5** | 203 (11,4%) | 424 (12,6%) |

- Зориудын урьдчилан сэргийлэх үзлэгээр 6 цэцэрлэг, 10 сургуулийн нийт 4311 хүүхэд урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан байна. Энэ нь урд онтой харьцуулбал 2533 хүүхдээр их байна.
- Шүд цоорох өвчний нийт тархалт 0-10 насанд 78,2%, эрчим 5 байв. 5-6 насанд шүд цоорлын тархалт 86,4%, эрчим 6, 12 насанд тархалт 63%, эрчим 2,3 байлаа. Энэ нь урд онтой харьцуулбал 0-18 насанд тархалт 0,5 % - р, 5-6 насанд тархалт 3,4%,12 насанд тархалт 4%-р ихэссэн байна.
- Нийт 6 цэцэрлэг, 10 сургуулийн 4311 хүүхдэд амны хөндийн эрүүл мэндийн видео хичээл, лекц, биечлэн болон харилцан яриа, АХА тэмцээний хэлбрээр сургалтыг явуулж, амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олголоо. ХУД-ийн 32, халамжийн 28-р цэцэрлэгийн 16 багш, 8 хүүхдэд тусгайлан сургалт явуулж, хүүхдүүдэд сургалт хийлгүүлэн шалгах замаар амны хөндийн эрүүл мэндийн сургагч багш,хүүхдүүдийг бэлтгэлээ. Лекц,видео сургалтанд 43 цаг,биечлэн сургалтанд 46 цагийг зарцуулсан байна.
- Халамжийн 4-р яслийн бага бүлгийн хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хүүхдийн шүдийг багаас нь хэрхэн арчлах талаар сургалт явуулж нийт 32 эцэг эх хамрагдлаа.
- ХУД-ийн харъяа цэцэрлэг, сургуулиудын эмч нар, эцэг эхийн төлөөлөлд “Амны хөндийн эрүүл мэндийн сургалтыг хэрхэн явуулах вэ?” сэдэвт сургалт явууллаа. Нийт 24 хүн оролцлоо.

| | | |
|---|---|---|
| | | ➢ Амны хөндийн эрүүл мэндийн сэдэвт 2 төрлийн санамжийг шинээр боловсруулан гаргаж, 450 ш-г сургууль, цэцэрлэгээр тараасан байна. АХЭМ-ийн сургалт сурталчилгааны ажилд нийт 11900 төгрөгийг зарцуулсан байна.<br><br>ХУЭМТ-ийн харъяанд шүдний 6 эмч,6 сувилагч ажиллаж байна. 2018 оны эхний хагас жилд нийт 19325 хүнд амны хөндийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж,анхдагчаар 6372 хүн үйлчлүүлсэнээс 2676 буюу 42% нь эрүүлжүүлсэн байна.<br><br>➢ ХУЭМТөвийн шүдний кабинетээс “Эрүүл хүүхэд - Эрүүл шүд” жилийн аяныг зохион байгуулж, зориудын урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс хамгийн их шүд цоорлын өвчлөлтэй гарсан 75-р сургуулийн 4б ангийн хүүхдүүдийг 100% эмчлэн эрүүлжүүлж, ”Эрүүл шүдтэй анги” өргөмжлөл гардууллаа.<br>➢ Халамжийн 28-р цэцэрлэгийн бэлтгэл ангийн хүүхдүүдийг 100% эрүүлжүүлж төгсгөлөө.<br>➢ Халамжийн 4-р яслийн хүүхдүүдийн эрүүлжүүлэлт 85% явагдлаа.<br>➢ Нийт амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 254 буюу 12,6% нь эрүүлжсэн байна. Урд онтой харьцуулбал эрүүлжилт 1,2%-р ихэссэн үзүүлэлттэй байна.<br><br>**Зорилт 3. Эрсдэлт бүлгийн хүн амыг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэнд хамруулж "Сүрьеэгүй Хан-Уул" хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж ажиллана**<br><br>ЭМС-ын 2017 оны 306 тушаалын дагуу эрсдэлт бүлгийн судалгааг 5 чиглэл, 22 бүлгээр 11294 хүний судалгааг шинэчлэн гаргаж нэгтгэсэн. 2018 оны 5-р сард өрхийн 301, ойрын 1977 нийт 2278 хавьтал үзлэгт хамрагдаад байна. 11/IV-14/V-ны хооронд ЭМТ, ӨЭМТ, сургуулийн захиргаатай хамтран хүүхдийн байгууллагад бүртгэгдсэн сүрьеэгийн ойрын хавьтлуудад эрт илрүүлэг зохион байгуулж ХӨСҮТ-ийн сүрьеэ тандалтын алба, хорих ангиас зөөврийн рентген аппарат, рентген техникчтэй хамтран ажиллалаа. Үүнд: 2018 онд сүрьеэ бүртгэгдсэн 7 ерөнхий боловсролын сургууль хамрагдсан.<br><br>➢ Туберкулины сорил- 487 сурагч,<br>➢ Сүрьеэ илрүүлэх асуумж судалгаа- 1977 багш ажилчид, сурагч,<br>➢ Цэрний түргэцийн болон жене Xpert шинжилгээнд – 113 багш ажилчид, сурагч,<br>➢ Рентген шинжилгээнд - 1977 багш ажилчид, сурагч хамрагдсан.<br><br>Үүний дунд: |

- 3 сурагч, багш сүрьеэгийн эмчилгээнд орсон.
- 38 багш, сурагчийн эмчилгээ, хяналтыг шийдвэрлэхээр ХӨСҮТ-ийн хүүхдийн сүрьеэгийн тасгийн зөвлөх эмч, дүрс оношлогооны эмч, дүүргийн диспансерийн болон сургуулийн эмч, тархвар судлаач нарын хамтарсан баг 1 удаа хуралдан, эдгээр багш сурагчдыг нарийвчилсан үзлэг, шинжилгээнд хамруулж үр дүнг хэлэлцэж шийдвэрлэхээр ажиллаж байна.
- 125 хүүхдэд урьдчилан сэргийлэх эмчилгээний горимыг хэлэлцэж байна.
- Мөн 4,5,6,7,8,9,10, хороодын эрсдэлт бүлгийн120 хүнийг рентген шинжилгээнд хамруулан 4 идэвхтэй хэлбэрийн уушигны сүрьеэ илрүүлэн эмчилгээнд хамруулсан.
- Цэргийн албанаас чөлөөлөгдсөн дүүргийн харьяа 5 иргэнийг үзлэгт хамруулж 2 идэвхтэй хэлбэрийн сүрьеэг илрүүлж эмчилж байна.
- Эрсдэлт бүлгийн нэн ядуу, эмзэг бүлгийн иргэдийн судалгааг шинэчлэн гаргасан. Үүнээс өвчтэй байж болзошгүй архи согтууруулах ундаа хэрэглэдэг 10 хүнээс цэрний шинжилгээг 2018 оны 03 сарын 29 авч зөөвөрлөсөн. Өвчлөл илрээгүй.
- Алслагдсан хороод Өлзийт Туул тосгон Био комбигатад сайн дурын идэвхтэн 4 хүнийг сурган нийт 8 хүний эмчилгээг гэрээр хүргэн уулгаж байна. Эрсдэлт бүлгийн хүн амд эрт илрүүлгийг гэрээр очиж хийх сайн дурын 14 хүнийг сурган “Дэмжих бүлэг “ ажиллаж 3 хүнийг илрүүлэн эмчилгээнд хамруууллаа.Эмзэг бүлгийн 5 өвчтөнд эмчилгээний хугацаанд сар бүр 50.000 төгрөгийн хүнсний тусламжийг МСТН Глобаль сантай хамтран олгож байн.ЗДТГын НХХэлтэстэй хамтран одоо эмчилэгдэж байгаа 140 хүмүүсийн амжиргааны түвшин тогтоож хороодын засаг дарга нартай хамтран хүнсний болон бусад тусламжинд хамруулах арга хэмжээ авснаар эмчилгээ таслалт 7% иас 2% болж буурсан.

**Сургалт сурталчилгаа:** Сургалтын төрөл, хамрагдсан хүний тоо

| № | Төрөл | тоо |
|---|---|---|
| 1 | Сургалт сурталчилгаанд хамрагдсан хүүхдийн байгууллагын багш ажилчид, сурагчдын тоо | 3175 |
| 2 | Сургалтанд хамрагдсан иргэдийн тоо | 2358 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | Өдөрлөг, АХА, зургийн тэмцээн зэрэг арга хэмжээнд оролцсон иргэдийн тоо | 1296 |
| 4 | Сургалтанд хамрагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн хүүхдийн байгууллагын эмчийн тоо | 50 |
| 5 | Сургалт, ярилцлаганд хамрагдсан өвчтөний тоо | 125 |
| 6 | Нийт хамрагдсан хүний тоо | 7004 |

2018-3-24-нд дүүргийн 4, 5, 6, 7, 8-р хорооны Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нийгмийн ажилтнууд томоохон дэлгүүр худалдааны төв, олон хүн цуглардаг газраар явж иргэдэд болон мэдээлэл авч чадахгүй байнга ажлын байран дээрээ тогтмол байдаг худалдагч, таксины жолооч, үүрэн телефоны оператор нарт сүрьеэ өвчний талаар мэдээлэл өгч сурталчилгааны материал тараасан.

Хамрагдсан байгууллага- 6, дэлгүүр-6, Хамрагдсан хүн -250

Сурталчилгаа – 250 ширхэг зөвлөмж, 151ш санамж, fb-10 удаа тараасан.

Дүүргийн онцгой байдлын хэлтэс, Улаан загалмайн хороо ЭМТөвийн Сүрьеэ диспансер, БЗДХ-ын кабинет хамтран 3-р сарын 26-нд Хүннү-Молл цогцолборт ард иргэдэд ”Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлье”, “Бид нэг агаартай сүрьеэ өвчнөөр хэнч өвдөж болно”, ”Гар халдваргүйтгэх арга, гараа хэрхэн зөв угаах “ Сүрьеэг тэглэе “ сэдвээр сургалт хийж, дүүргийн 4,5,6,9,16-р хороодын иргэд идэвхтэй оролцож сурталчилгаа явуулан 250 хүн хамрагдаж сурталчилгааны материал тарааж, NTB телевиз-д иргэдэд зориулсан ярилцлага өгөн ажиллалаа.

3-р сарын 21-нд ВКК, ВТЭК орох амбулаториор үйлчлүүлж байгаа 120 хүнд “Сүрьеэ өвчний халвдарлах зам” “Хүүхдийн сүрьеэг эрт оношлох, хавьтлыг урьдчилан сэргийлэх үзлэгт эрт оруулахын ач холбогдол” сэдвээр сургалт хийж сургалчилгааны материал тараасан .

Ард иргэдэд сүрьеэ өвчний талаарх эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, идэвхи оролцоог нэмэгдүүлэх зорилготой 2018 оны 03 сарын 27 өдөр АХА тэмцээнд нийт 56 иргэд, Өрхийн эрүүл мэндийн төв, хороо хамтран “Бидний мэдэх сүрьеэ өвчин” сэдвээр гар зургын уралдаанд 8 багийн 40 хүн оролцож сүрьеэ өвчний талаарх мэдлэгээрээ өрсөлдөж явагчаа тодруулж шагнал гардуулсан. Нийт ард иргэдэд “Зөв ханиаж найтаалгах”

| | | |
|---|---|---|
| | | дадлыг хэвшүүлэх талаар цахимаар сурталчилгааг 60 хүн шейрлэж, мэдээлийн сувгаар сургалт сурталчилгаа явууллаа.<br>Тэмдэглэлт өдрийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах зорилгоор UBS ТВ-д 2 удаа, NTV телевизэд ярилцлага өгсөн. TV-5 теливизээр сургагч багш Л.Оюунтуяа сүрьеэ өвчний өнөөгийн төлөв байдал иргэдэд мэдээлэх олгох талаар ярилцлага өглөө.<br><br>TV-5, лайк ТВ, UBS TV-р болон 16 хорооны ӨЭМТ, ЭМТ-ийн цахим хуудсаар 81 удаа “Сүрьеэ өвчин эдгэрдэг”, Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл зөвлөмж хүргэсэн. |
| | | **Зорилт 4. Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд нийгэм, хамт олонд мансууруулах бодисын хор нөлөөг сурталчилах ажлыг цагдаагийн байгууллагатай хамтран ЕБС-уудын дунд зохион байгуулах ажлыг эрчимжүүлнэ**<br>Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ЕБС-дад сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас “Архи тамхины хор хөнөөл” сэдэвт сургалтыг дараах байдлаар зохион байгууллаа:<br>✓ 2018.02.20-нд 32-р дунд сургуулийн 5-12-р ангийн 729 сурагчдад хамрагдсан.<br>✓ 2018.03.02-нд ЕБ 7-р сургуулийн ахлах ангийн 460 сурагч хамрагдсан.<br>✓ 2018.03.06-ны өдөр ЕБ 115-р сургуулийн ахлах ангийн 32 сурагч хамрагдсан.<br>✓ 2018.03.12 ЕБ 15-р сургуулийн ахлах ангийн 35 сурагч хамрагдсан.<br>✓ 2018.03.15-нд ЕБ 41-р, Оном сургуулиудын ахлах ангийн 160 орчим сурагчдад сургалтыг тус тус зохион байгууллаа. |

| | | |
|---|---|---|
| | | ✓ 2018.04.12–нд ЕБ-н 10, 26-р сургуулиуд дээр “Архи тамхи, сэтгэц нөлөөт бодисын хорт нөлөө, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдэвт сургалтыг хийсэн. Сургалтанд ахлах ангийн нийт 210 орчим сурагч хамрагдлаа.<br>✓ 2018.04.17–нд ЕБ-н 59-р сургуулийн ахлах ангийн 120 сурагч сургалтанд хамрагдлаа.<br>✓ 2018.04.19–нд “Буянт- Ухаа” цогцолбор сургуулийн ахлах ангийн 150 орчим сурагч хамрагдлаа.<br>✓ 2018.04.24-нд ЕБ-н 75-р сургуулийн ахлах ангийн 180 сурагч хамрагдлаа.<br>2018.04.27 –нд ЕБ-н 32-р сургуулийн ахлах ангийн 100 орчим сурагчидад<br>✓ сургалт зохион байгууллаа.<br>2018 оны эхний хагас жилийн байдлаар сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас архи, тамхины хор хөнөөл сэдвийн хүрээнд 10 удаагийн сургалтыг ЕБ-н 9 сургуульд зохион байгуулсан байна. Сургалтанд нийт 2176 ахлах ангийн сурагчид хамрагдлаа<br>Сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас 2018 оны 6 сарын 14,15-нд дүүргийн Өрхийн эрүүл мэндийн төвийн эмч, нийгмийн ажилтангуудыг чадавхжуулах **“Архи тамхи, мансууруулах, сэтгэц идэвхт бодисын хэрэглээ, түүний эрсдлийг эрүүл мэндийн анхан шатны байгууллагын түвшинд эрт илрүүлж, үнэлж, богино хугацааны эрчимтэй зөвлөгөө өгөх /Assis**t/ сэдэвт сургалтыг зохион байгууллаа. Сургалтанд НЭМГ харъяа Наркологийн эмнэлэг, “Сандоз”, “Олайнфарм” эмийн кампаниуд хамтран сургалтыг дэмжин оролцлоо. Сургалтанд нийт 32 өрхийн эмч хамрагдлаа.<br>Хан-уул дүүргийн нутаг дэвсгэрт байрлах их, дээд сургууль, коллежуудад сэтгэцийн эрүүл мэнд, наркологийн кабинетаас “Архи тамхи, мансууруулах, СИД” сэдвийн хүрээнд дараах сургалтуудыг зохион байгууллаа:<br>✓ 2018.02.28-ны Монгол Солонгосын хамтарсан Политехникийн коллежид сургалт хийж 130 оюутан хамрагдлаа.<br>✓ 2018.04.23 –нд Технологийн дээд сургуулийн 113 оюутанд сургалт зохион байгууллаа. |

| | | |
|---|---|---|
| | | ✓ 2018.04.24-нд “Орхон” дээд сургууль дээр сургалтыг зохион байгуулж, сургалтанд 140 оюутан хамрагдсан.<br>✓ 2018.04.25-нд “Аварга” ДС дээр “Архи тамхины хор хөнөөл” сэдэвт сургалтыг хийж 134 оюутан хамрагдлаа.<br>✓ 2018.04.26-нд ҮЭЗДС дээр “Архи тамхины хор хөнөөл” сэдэвт сургалтыг хийж 64 оюутан хамрагдлаа<br>2018.04.27 –нд Хөдөө аж ахуй их сургуулийн нийт 500 гаруй оюутанд архи, тамхи, мансууруулах сэтгэц идэвхит бодисын талаар сургалтыг зохион байгууллаа.<br>**Зорилт 5. Ахмад настнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт бүрэн хамруулна**<br>1. ХУД-ийн 4,5,6,7,9,10,14,15, –р хороодын ахмад настнуудад халдварт болон халдварын бус өвчний эрт илрүүлэг хийх урьдчилан сэргийлэх үзлэгийг дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, хавдар, нүд лор, сүрьеэ гм төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг нийт 5243 ахмадуудад хийсэн.<br>2. Ахмад настны дунд эрүүл аж төрөх зан үйлийг дэмжих сургалт сурталчилгааг дараах сэдвүүдээр явуулж ирлээ. Үүнд: Осол гэмтлээс сэргийлэх, Эрүүл зөв хооллолт, Дасгал хөдөлгөөний ач холбогдол, Архи тамхины хор уршиг, эмийн зохистой , Хорт хавдараас сэргийлье, АД ихсэх өвчнөөс сэргийлье, Чихрийн шижин чимээгүй тахал сэдэвт сургалтанд 1523 ахмад хамрагдсан.<br>3. Мөн эдгээр сэдвүүдээр гарын авлага, брошур хийж 1678 ахмадуудад тараасан ба ганцаарчилсан зөвлөгөө зөвлөмжийг 1218 ахмадуудад өгсөн.<br>4. Эрүүл мэндийн 4 ба 5-р бүлэгт хамрагддаг ахмад настанг гэрийн эргэлт тогтмол графикийн дагуу хийж шаардлагатай тохиолдолд нарийн мэргэжлийн эмч нарт дуудлагаар үзүүлж байна.<br>5. “Элэг бүтэн Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2807 ахмадуудадэлэгний В,С вирус илрүүлэх эрт илрүүлгийн шинжилгээнд хамруулсан.<br>6.Умайн хүзүүний хавдарыг эрт илрүүлэх умайн хүзүүний эсийн шинжилгээнд 856 ахмадуудыг хамруулсан байна. |
| Хоёрдугаар бүлэг: “Тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, үр дүн”-ийн хэрэгжилт | | |

| | | Эрх зүйн актын нэр он, сар, дугаар | ХЭРЭГЖИЛТ |
|---|---|---|---|
| 1,2 | а/Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаварын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл: | 1 | 2 |
| | | НЭГ.ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ | |
| | | Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил зарлах тухай<br>Дугаар 38<br>2018.05.01 | Ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар 2017 оны 08 сран 15-ны А/56 тоот тушаалаар Ёс зүйн хэсгийн хороог шинчлэн 7 хүний бүрэлдэхүүнтэй баталсан.<br>• Хөндлөнгийн хяналтыг графикийн дагуу тусгай асуумжаар явуулсан.<br>• Ажилтнуудын даган мөрдөх үйдчилгээний стандарт сургалтыг зохион байгуулсан.<br>• Шинээр ажилд орсон эмч , сувилагч , ажилчидад эмнэлгийн дотоод журам,ЭМС-н 446 тоот тушаалаар хичээл заасан.<br>Мөн нийт эрүүл мэндийн төвийн болон өрхийн эрүүл мэндийн төвийн 80 гаруй эмч нарт “Зөрчлийн тухай хууль”, “Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль” зэрэг хуулийг танил мэдүүлэх эрсдэлээс хамгаалах, алдаа зөрчил гаргахгүй байх үүднээс уг сургалтыг НЭМГ-н Бодлого төлөвлөлтийн албаны дарга, АУ-ны доктор, ХЗУ-ны магистр Одгэрэл даргаар жишээ дээр тулгуурласан сургалт ярилцлагыг амжилттай зохион байгууллаа. тулгуурласан сургалт, ярилцлагыг амжилттай зохион байгууллаа. |
| | | НЭГ.ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ | |
| | | 2018 оныг “Хариуцлагын жил” болгон зарлах тухай | Үндэсний хөтөлбөрүүд тус тусын төлөвлөгөөний дагуу “Хэрэгжих шатанд”-тавьсан зорилтдоо бүрэн хүрээгүй боловч төсөв, хөрөнгө санхүүтэй холбоотой асуудлыг шийдвэрлэсэн, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, дээд шатны байгууллагад өргөн барьсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн нь гарч байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2018.01.31 №32 | • Байгууллагын даргын 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн А/107 тоот тушаалаар албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан бөгөөд уг төлөвлөгөөний дагуу Хүний нөөцийн албанаас байгууллагын нийт эмч, ажилтнуудын дагаж мөрдөх хууль, дүрэм, зааврын жагсаалтыг шинэчлэн гаргаж ил тод байдлын самбарт байршуулсан.<br>• Сахилга хариуцлага дэг журмыг сайжруулах, архидан согтуурахтай тэмцэх зорилгоор Байгууллагын даргын 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн “Зөвлөл байгуулах тухай” А/20 тоот тушаалыг батлуулсан. Зөвлөлийн бүрэлдэхүүн Хан-Уул эрүүл мэндийн төвийн дэргэдэх Ёс зүйн салбар хороотой хамтран төлөвлөгөө, хуваарь гарган ажиллаж байна.<br>• 2018.05.02-ны өдөр байгууллагын нийт эмч, ажилтнуудад “Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн- сургалт зохион байгуулсан ба 104 ажилтан хамрагдсан.<br>• Иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын тоо 2018 оны эхний хагас жилийн байдлаар 76 ба 66 өргөдөл шийдвэрлэгдэж, 10 өргөдөл шийдвэрлэх шатандаа байна. Өргөдөл гомдлын тайланг 14 хоног, улирлаар тогтмол НЭМГ-т хүргүүлж байна.<br>• Ёс зүйн салбар хороо тогтмол хуралдаж ёс зүйн алдаа зөрчил гаргасан ажилтнуудад хариуцлага тооцох, үр дүнгийн урамшуулалд  арга хэмжээ авах, эмч мэргэжилтнүүдийн ёс зүйн хэм хэмжээг сайжруулах ажлыг тогтмол зохион байгуулж хэвшсэн. Мөн шинээр орж буй ажилтнуудаас ёс зүй, харьцаа хандлагын тестийг тухай бүр авч байна. |
| | | | - Ахмад настнуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах удирдамжийг 2018 оны 02 дугаар сард ЭМТ-ийн даргаар  батлуулан дүүргийн 16 хорооны бүх ахмад настнуудыг хуваарийг дагуу үзлэгт хамруулахаар төлөвлөн эхний хагас жилийн байдлаар 4,5,6,7,10 дугаар хорооны 457 ахмад настныг үзлэгт бүрэн хамруулсан.<br>- Цэргийн насны залуусыг эрүүлжүүлэх тухай ЭМТ-ийн даргын 2018 оны А/14 дүгээр тушаал батлагдан дүүргийн цэргийн насны 1600 залуусыг эрүүлжүүллээ. |

| | | | |
|---|---|---|---|
| | Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын холбогдолтой мэдээлэл: | | - Нөхөн үржих насны хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажлын удирдамжийг 2018 оны 02 дугаар сард ЭМТ-ийн даргаар батлуулан дүүргийн 1,8,15,16 дугаар хорооны нөхөн үржихүйн насны 320 эмэгтэйчүүдийг үзлэг шинжилгээнд бүрэн хамруулсан. Дүүргийн 3,11,15 дугаар хорооны ЕБС, цэрэглэгийн хүүхэд багачуудыг халдварт өвчний урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан. - Ахмад настнуудыг архаг өвчний хүндэрлээс сэргийлж, амьдралын чанар дээшилнэ.<br>- Цэргийн насны залуусын эрүүл мэндийн үзүүлэлт сайжирч, цэрэгт татагдах хувь нэмэгдэнэ.<br>- Нөхөн үржихүйн насны хүн амын эрүүл мэнд сайжирна.<br>- Хүүхэд багачуудын дундах амны хөндийн өвчин, халдварт өвчин буурна. |
| | | ХОЁР.ЗАСГИЙН ГАЗРЫН АЛБАН ДААЛГАВАР | |
| | | "Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай" Засгийн газрын АЛБАН ДААЛГАВАР 2017.10.25 №01 | Хан-Уул эрүүл мэндийн төвийн албан хаагчид шударга ёс, хууль дээдлэх зарчим баримтлан, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, улс төрөөс ангид, мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ажиллах зорилгоор Хуулийн зөвлөх Бадамханд 2018 оны 03 дугаар сарын 15-ны өдөр сургалт зохион байгуулж, лекц хэлэлцүүлэх явуулсан. |
| | | | 1.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, батлуулсан.<br>2.Байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт авлигын эсрэг хууль, тогтоомж, зөвлөмж, байршуулсан.<br>3.Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд “Гэрээт харуул хамгаалалт” үнэлгээний хороонд хяналт тавьж ажилласан. |
| | | | 2018 оны 2-р улирлын байдлаар тус эрүүл мэндийн төвд иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдол нийт 42 байна. Үүний 30 нь Засгийн газрын 11-11 төвөөр, 12 нь байгууллага дээр удирдлагын багийн гишүүд хуваарийн дагуу бүртгэж хүлээн авсан талархал, өргөдөл гомдол байна.<br>Иргэдээс ирсэн нийт өргөдөлийн |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ➢ Гомдол -54,76<br>➢ Талархал -14,28%<br>➢ Хүсэлт – 26,19%<br>➢ Санал -4,76%<br>2018 оны 2 дугаар улирлын байдлаар иргэдээс ирсэн өргөдөл гомдол шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 11 цагтай байна.<br>Өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцон ажиллаж байна<br>Үүнд: Ёс зүйн хэсгийн хорооноос хэлж анхааруулсан 4 эмч,<br>Удирдлагын зөвлөлийн хурлаар орж, хурлын шийдвэрээр сахилгын сануулах арга хэмжээ авсан-2 эмч, үндсэн цалинг 20%-иар бууруулах сахилгын шийтгэлийг 2 сувилагчид авсан. |
| | | | Байгууллагын даргын 2016 оны А/15 тоот тушаалаар баталсан ажлын цаг ашиглалтын журмыг мөрдөн ажилладаг бөгөөд чөлөө зөвшөөрлийн хуудсаар ажилтнуудад чөлөө олгох, хоцролт болон ажлын цаг ашиглалтын байдлыг ажилтны үр дүнгийн урамшууллаар тооцох, гадуур ажлын бүртгэлийн дэвтэр хөтлөх зэргийг хэвшүүлж дадсан. Жилийн турш өвчлөл, чөлөө, таслалтгүй ажилласан ажилтанг жилийн эцэст үндсэн цалингийн 20%-иар урамшуулах зэрэг<br>Мөн ажилтан, албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах, үүрэгт ажлаа чанартай, үр дүнтэй хийж гүйцэтгэх, ажлын байрны дэг журмыг сайжруулах зорилгоор төвийн даргын 2018 оны 02 сарын 01- ний А/08 тоот тушаал гарган хяналт шалгалт хийж, 1 сарын аяныг зохин байгуулав. |
| | | | 2018 оны 01 сард нийт эмч ажиллагсдаас сургалтын хэрэгцээний судалгаа авч нэн шаардлагатай байгаа төрөлжсөн нарийн мэргэжлээр сургах талаар НЭМГазарт санал, судалгааг хүргүүлсэн. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 75 дугаар тогтоол, Засгийн газрын 1997 оны 88 дугаар тогтоол, Хан-Уул эрүүл мэндийн төвийн Хамтын гэрээний 3.1 дахь заалтын дагуу 2018 онд нийт 35 ажилтан албан хаагчийн цалингийн шатлалыг нэмэгдүүлсэн.<br>2018 оны 01 дүгээр улиралд нийт ажилчдын сэтгэл ханамжийн судалгаа авч дүнг үр дүнд үндэслэн төлөвлөгөө боловсруулалтын шатанд явагдаж байна. |
| | | | Албан тушаалтны сахилга, хариуцлагыг өндөржүүлж, аливаа ажил, асуудлыг цаг алдалгүй шуурхай зохион байгуулж гүйцэтгэлийн явц, үр дүнд тавих хяналтыг сайжруулан хүлээлгэх хариуцлагыг чангатгаж, төрийн албаны стандартыг мөрдүүлж ёс зүйн салбар хороо хүний нөөцийн албатай хамтран шинээр ажилд орсон нийт ажиллагсдад 446 тоот тушаалыг танилцуулан ажиллаж байна. |
| | | | Төвийн албан ёсны вэбсайт http://www.huemn.ub.gov.mn эрх зүй гэсэн цонхонд Монгол улсын хууль, ЗГ-ын тогтоол шийдвэр, албан даалгавар ,ЭМСайдын тушаал, албан даалгавар, ХУДЗД-ын албан даалгавар захирамж, Төвийн даргын тушаалыг тухай бүр шинэчлэн тавьж байна.<br>Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйл, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 29 дүгээр тогтоолын 3.2 үндэслэн төвийн даргын 2018 оны 04 сарын 17ний өдрийн А/42 тушаал “Журам батлах тухай” Шилэн дансны нэгдсэн портал систем, Хан-Уул Эрүүл Мэндийн төвийн цахим хуудсанд мэдээллийг байршуулах журмыг мөрдөн ажиллаж байна.<br>Сул орон тооны зарыг тухай бүр шинэчлэн ил тод байдлын самбар болон байгууллагын цахим хуудсанд байршуулж байна.<br>Нээлттэй ажлын байрны зарыг байгууллагын цахим хуудсуудаар /вэб сайт, фэйсбүүк хуудас/ тухай бүрт нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалт явуулдаг. Мөн байгууллага дээр зохион |

| | | | |
|---|---|---|---|
| | | | байгуулагдсан олон нийтийн арга хэмжээ, цаг үеийн мэдээллийг цахим хуудсуудаар дамжуулан тогтмол мэдээллэн ажиллаж байна. |
| | | | Эмч эмнэлгийн ажилчдын ёс зүйн хэм хэмжээний журмыг байгууллагын вэб хуудсанд байршуулсан бөгөөд Хан-Уул эрүүл мэндийн төвийн ёс зүйн салбар хорооны танилцуулга, үйл ажиллагааны төлөвлөгөө мэдээллийг танилцуулах танилцуулгын булан ажиллуулж байна. |
| | | | Эмч, эмнэлгийн ажилчдын ажлын үр дүнг тооцож ажиллах гүйцэтгэлийн үнэлгээний журмыг багийн зохион байгуулалтаар дүгнэж, Гүйцэтгэлийн үр дүн, урамшууллыг 1 улирлын байдлаар дүгнэж, урамшууллыг олгосон. |
| | | | 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу дараахь ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Үүнд:<br>1. Эх барих, эмэгтэйчүүд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэг цэгт төвлөрүүлэн ажиллаж байна.<br>2. Халдварт бус өвчний “Эрт илрүүлгийн цэг” ажиллаж байна<br>3. Цахим бүртгэлийн нэг цэгийн үйлчилгээ тогтмолжиж хэвийн ажиллаж байна. |
| | | ЗУРГАА.НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ | |
| | | 2018 оныг “Иргэдийн оролцоотой- Амьдрах орчныг сайжруулах жил” болгон зарлах тухай<br><br>2018.01.02 А/01 | ЭМТ-ийн гадна, дотор тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог хангах чиглэлээр ЭМТ-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| | | | 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Нийслэлийн аудитын газрын шалгалт хийгдэж 9,509,900 төгрөгийн зөвлөмж өгсөн. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Гүйцэтгэлийн гэрээ байгуулах тухай<br><br>2018.01.29 А/83 | НЗД-ын 2018 оны А/83 тоот захирамж, НЭМГ-ын даргын А/08 тоот тушаалын дагуу ЭМТ-ийн даргын А/11 тоот тушаал гарч Дүүргийн Засаг дарга, ЭМТ-ийн дарга нар дүүргийн 15 хорооны Өрхийн эрүүл мэндийн төвийн дарга нартай 02 дугаар сарын 15-ны өдөр 3 талт гэрээ байгууллаа. 2017 оны жилийн эцсийн үнэлгээгээр Ажил сайжруулах шаардлагатай үнэлгээ авсан 4 дүгээр хорооны "Цэц до" Өрхийн эрүүл мэндийн төвийндаргыг сольж ажил эрчимжүүлэх төлөвлөгөө батлан хагас жилээр гэрээ байгууллаа.<br><br>Дүүргийн Засаг дарга, ЭМТ-ийн даргатай байгуулсан 2017 оны гэрээний жилийн эцсийн үнэлгээгээр А буюу Бүрэн хангалттай үнэлгээ авсан 6 Өрхийн эрүүл мэндийн төвийндарга нарт урамшуулал олгох тухай хүсэлтийг Дүүргийн Засаг даргад 02 дугаар сарын 28-ны өдөр 01/139 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЭМТ-ийн даргын А/41 тоот тушаалаар 2017 оны 3 талт гэрээгээр "Бүрэн хангалттай" үнэлгээ авсан Өрхийн эрүүл мэндийн төвийндарга нарт 1 сарын цалин, "Хангалттай" үнэлгээ авсан Өрхийн эрүүл мэндийн төвийндарга нарт 80%-тэй тэнцэх цалингийн урамшуулал олгохыг зөвшөөрсөн тушаал гарган хэрэгжүүллээ. |
| | | | Дүүргийн Засаг дарга, ЭМТ-ийн даргатай байгуулсан 2017 оны гэрээний жилийн эцсийн үнэлгээгээр А буюу Бүрэн хангалттай үнэлгээ авсан 6 Өрхийн эрүүл мэндийн төвийндарга нарт урамшуулал олгох тухай хүсэлтийг Дүүргийн Засаг даргад 02 дугаар сарын 28-ны өдөр 01/139 тоот албан бичгээр хүргүүлсэн. ЭМТ-ийн даргын А/41 тоот тушаалаар 2017 оны 3 талт гэрээгээр "Бүрэн хангалттай" үнэлгээ авсан Өрхийн эрүүл мэндийн төвийндарга нарт 1 сарын цалин, "Хангалттай" үнэлгээ авсан Өрхийн эрүүл мэндийн төвийндарга нарт 80%-тэй тэнцэх цалингийн урамшуулал олгохыг зөвшөөрсөн тушаал гарган хэрэгжүүллээ |
| | | Төлөвлөгөө батлах тухай<br><br>2018.01.31 А/86 | ЭМТ-ийн гадна, дотор тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд иргэдийн оролцоог хангах чиглэлээр ЭМТ-ийн 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. |
| | | | ДОЛОО.НИЙСЛЭЛИЙН УДИРДЛАГУУДААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР |

| | | | |
|---|---|---|---|
